

ТАНИЛЦУУЛГА

“Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2016 оны нэгдсэн чуулганаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг баталснаас хойш эдүгээ 6 жилийн хугацаанд хуульд заасан эрх зүйн зохицуулалтыг хуулийн үйлчлэлд хамаарах төрийн цэргийн байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль зүйн үндэслэл шаардлагын хувьд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 33-т “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Монгол Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.9-т “Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.” гэж заасан.

2017 онд Монгол Улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн (Stand by) хөтөлбөрт хамрагдах нөхцөл, шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Тухайлбал,

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.17-д “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох”, 7.1.21-д “Цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох” гэсэн зохицуулалтуудыг тус тус хүчингүй болгосон.

Мөн тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10-т “гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлсийг ... төр хариуцах”-тай, 9 дүгээр зүйлийн 9.5-д “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах”-тай холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг тус тус өөрчилсөн.

Дээрх хуулийн өөрчлөлтүүд нь цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг дордуулж, албандаа итгэх итгэл, алба хаах хүсэл зориг, эрмэлзлийг бууруулж, эрх ашгийг нь зөрчсөн, зэвсэгт хүчний алслагдсан болон хөдөө орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагч нар цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад ажиллах сонирхлыг бий болгож, ингэснээр цэргийн алба хаагч нарын алба хаах хүсэл сонирхол илт буурч, жилээс жилд ажлаас чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд томилогдох зэрэг сөрөг үр дагаврууд сүүлийн 5 жилийн хугацаанд гарч, хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Иймд цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, албандаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эрх ашгийг нь хамгаалах, зэвсэгт хүчний үндсэн чиг үүргийг алдагдуулахгүй байх зорилгоор хүчингүй болсон зохицуулалтуудыг бусад шаардлагатай улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа цэргийн алба хаагчийн ажил, албан үүргийг хуулиар албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох, ажлын байрны бэлгийн дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг алба хаагчдын үйл ажиллагаанд хориглох гэсэн зохицуулалтуудын хамт хуулийн төсөлд нэмэлтээр тусгах нь зүйтэй гэж үзсэн.

Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилж, алслагдсан болон орон нутагт байрлах цэргийн анги, салбарт тогтвор суурьшилтай ажиллах, албаны хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа хангагдах нөхцөл нэмэгдэж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6-д “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.” гэсэн зорилт хангагдах юм.

Улс орны төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай холбогдуулан хуулийн төсөлд тусгагдсан зардал гарахтай холбоотой 7.1.22 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 7.1.23 дахь заалт болон 9.2 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөхөөр Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгасан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудтай нийцэж байгаа болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

БАТЛАВ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

Г.САЙХАНБАЯР

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д “Улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах” гэж, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Батлан хамгаалах талаар Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 11.1.3-т “цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 33-т “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Монгол Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.9-д “Цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулна.” гэж тус тус заасан байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага

2017 онд Монгол Улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн (Stand by) хөтөлбөрт хамрагдах нөхцөл, шаардлагын дагуу Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан цэргийн алба хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой 5 эрх зүйн зохицуулалтыг хүчингүй болгосон.

Тодруулбал, тус хуулийн 7 дугаар зүйлд заасан “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох” гэсэн, мөн хуулийн “Цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох” гэсэн зохицуулалтуудыг хүчингүй болгож, гадаадын цэргийн сургуульд суралцаж

байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгохтой холбогдсон зарим эрх зүйн зохицуулалтуудад өөрчлөлт оруулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт алслагдсан болон аймгийн төвөөс бусад суманд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт мөнгөн урамшуулал олгох эрх зүйн зохицуулалтыг тус тус тусгаснаар тухайн байгууллагуудын алба хаагчийн эрх зүйн байдал сайжирч, албандаа итгэх итгэл, алба хаах хүсэл зориг, эрмэлзэл нь нэмэгдсэнээр хөдөө орон нутагт ажиллах хүний нөөцийн чадавх нь сайжирсан байна.

Үүнтэй зэрэгцэн зэвсэгт хүчний алслагдсан болон хөдөө орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагч нар дээрх нэр бүхий байгууллагад ажиллах сонирхол бий болж, цэргийн алба хаагч нарын алба хаах хүсэл сонирхол илт буурч, 2020 онд ..., 2021 онд ..., 2022 оны эхний 06 сарын байдлаар ... цэргийн алба хаагч ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд томилогдох зэрэг сөрөг үр дагаврууд жилээс жилд нэмэгдэж байгаа нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах хуулиар онцгойлон заасан зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг алдагдах, хүний нөөцийн хомсдол үүсэх шалтгаан бий болж байна.

Мөн Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас 2019 онд баталсан “Хүчирхийлэл, дарамтын тухай” 190 дүгээр Конвенцод нийцүүлэн 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсан бөгөөд тус хуульд нийцүүлэн цэргийн алба хаагч ажлын байрны бэлгийн дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар гадаад, дотоодын цэргийн сургуульд суралцаж буй алба хаагч албан тушаалын цалин болон хуульд заасан нэмэгдлийг тооцон авч, уг цалин хөлсийг үндэслэн цэргийн алба хаасан хугацаанд тооцох зохицуулалттай байсан.

Гэвч цэргийн сургуульд суралцах хугацаандаа авдаг байсан цалин, хөлсийг “тэтгэлэг” болгон өөрчилснөөс тухайн алба хаагчийн ажилласан жилийг тооцоход цалин хөлс гэж тооцох боломжгүй болж, ялангуяа тэтгэвэр тогтоолгоход ажилласан жилд тооцогдохгүй байгаа нь цэргийн алба хаагчийн нийгмийн баталгааг дордуулах нөхцөл үүсэж байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгааг өмнө нь хүчин төгөлдөр үйлчилж байсан хэмжээнд хүргэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх, мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэн эмэгтэй алба хаагчийн хуульд заасан эрхийг хангах зорилгоор алба хаагчийн тодорхой үйл ажиллагааг хязгаарласан зохицуулалтуудыг тусгасан Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар:

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Алслагдсанд тооцох цэргийн анги, байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал болон цэргийн дээд офицер алба хаасны тэтгэвэр тогтоолгохдоо урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг олгох талаар тусгана.

Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд цэргийн алба хаагч оролцох нь албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцогдох, ажлын байрны бэлгийн дарамт, шахалт, ялгаварлан гадуурхахыг хориглох зэрэг зохицуулалтын талаар тусгана.

Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох зохицуулалтыг өөрчилж, эрх зүйн байдлыг дээшлүүлсэн зохицуулалт тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар:

Хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын баталгааг өмнө нь хүчин төгөлдөр үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтын хэмжээнд хүргэх, алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа хангагдахаас гадна Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэн холбогдох зохицуулалт орсноор эмэгтэй алба хаагчдын хуульд заасан эрх хангагдана.

Хуулийн төслөөр дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд нь баталдаг болсноор хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын алба хаагч нарын нийгмийн баталгаа хангагдах юм.

Түүнчлэн алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт таван жил болон түүнээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг таван жил тутамд нэг удаа олгох, цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох, цэргийн алба хаагчид олгох нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцоход улсын төсвөөс жилдээ нийт ... төгрөгийн нэмэлт зардал шаардагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараах хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 11 дэх заалт:

“4.3.11.улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох;”

2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 22, 23 дахь заалт:

“7.1.22.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална;

7.1.23.цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.”

3/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

“8.1.10.ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах;”

2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“9.2.Цэргийн алба хаагчид дараах нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцон олгоно:”

2/9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“9.5.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.3.11.” дэх заалтын дугаарыг “4.3.12.” гэж, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “тусламжид” гэснийг “мөнгөн тусламж, урамшуулалд” гэж, 8 дугаар зүйлийн “8.1.10.” дахь заалтын дугаарыг “8.1.11.” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “...хилийн отряд, застав болон...” гэснийг “алслагдсанд тооцогдсон цэргийн анги,

салбар болон хилийн цэргийн анги,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “удаан жил ажилласны” гэснийг “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “анги, агаарын цэргийн салбарт” гэснийг “ангид” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 87.11 дэх хэсэг нэмсүгэй:

“87.11.Дотоод, гадаадын цагдаагийн их, дээд сургуульд суралцаж байгаа цагдаагийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалт болон 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан хугацаанаас өмнө Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэгт заасан хувиар тооцуулан мөнгөн урамшууллаа авсан алба хаагчийн алслагдсан анги, салбарт 5 ба түүнээс дээш жил алба хаасан мөнгөн урамшууллыг хамгийн сүүлд мөнгөн урамшуулал авсан хугацаанаас нь эхлэн тооцож олгоно.

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.22 дахь заалтад заасан мөнгөн урамшуулал олгох журмыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах ажлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЭЛЭЛЦСЭН нь: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад, Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

2022 ОН
ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Монгол Улсын батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, 2017 онд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 2018 онд Орон нутгийн хамгаалалтын тухай, Дайчилгааны тухай, Улсын нисэхийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудыг шинээр болон шинэчилсэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулах замаар Монгол Улсын Зэвсэгт хүчин, түүний бие бүрэлдэхүүний алба хаах нөхцөл бололцоо, нийгмийн баталгааг сайжруулах зэргээр батлан хамгаалах салбарын гол гол хуулиудын эрх зүйн орчныг боловсронгуй болгосон.

2017 онд Монгол Улсын төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон Улсын Валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн /Stand by/ хөтөлбөрт хамрагдах нөхцөл, шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан нь цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа, эрх зүйн байдлыг дордуулсан юм.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.17, 7.1.21 дэх заалтад заасан хуулийн зохицуулалтыг хүчингүй болгож, мөн зүйлийн 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан хуулийн зохицуулалтад өөрчлөлт оруулсан юм. Тодруулбал:

-“7.1.17.улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;

-“7.1.21.цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицер т урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох” гэсэн заалтуудыг хүчингүй болгосон.

Түүнчлэн 7.1.10 дахь заалтын “гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлсийг ... төр хариуцах” гэж заасныг “сургалтын тэтгэлэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж тус тус өөрчилсөн нь цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг бууруулсан зохицуулалт болсон юм.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтоох, төрөөс цэргийн алба хаагчийн эдийн засаг, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн байдаг.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүчингүй болгосон зарим заалтыг уг хуульд буцаан тусгах, өөрчлөлт оруулсан заалтыг хуучин хүчин төгөлдөр үйлчилж байснаар өөрчлөн найруулж хуульчлах, ингэснээр цэргийн алба хаагчдын эрх зүйн баталгааг хуучин мөрдөж байсан зохицуулалтын төвшинд хүргэх зайлшгүй шаардлага бий болсон.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг”-ийн 5.6-д “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, мөн хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 33-т “Цэргийн

а
л
б
а

х
а
а

г Монгол Улсын Их Хурлын 2016 оны нэгдсэн чуулганаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг баталснаас хойших 6 жилийн мугацаанд тус хуулийн үйлчлэлд хамаарах төрийн цэргийн байгууллагууд йэрэгжилтийг ханган ажиллаж байна.

н

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

з Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг Засгийн газар баталж мөрдүүлнэ.” гэж, 13 дугаар зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” гэж тус тус заасны бүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын (цаашид “Аргачлал” гэх) 2.1-т заасан үе шатны дагуу гүйцэтгэв.

д
л
ы
н

т
у
х
а
й

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал:

х
у

Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг оновчтой тогтоож, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлохоор зорилоо.

Эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийг баталсан ба 5.6 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 6.4 дэх хэсэгт “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.” гэж заасны хүрээнд 2016 онд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, 2017, 2021 онд тус тус өөрчлөлт орсон.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар Монгол улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтоож, цэргийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь цэргийн алба хаагчийн эдлэх нийтлэг эрх, үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгаатай холбогдох харилцаанаас гадна цэргийн алба хаагчийн давуу эрх, хүлээх нийтлэг үүрэг, эрхийн хязгаарлалтыг тогтооход чиглэдэг.

2017 онд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь Монгол Улсын төсөв, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах арга хэмжээний хүрээнд Олон улсын валютын сангийн хөнгөлөлттэй зээлийн /Stand-by/ хөтөлбөрт хамрагдах нөхцөл, шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 заалтыг хүчингүй болгож, 3 заалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа, эрх зүйн байдал дордсон байна.

Үүний үр дүнд цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт олгодог байсан цолны цалинг, мөн улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас тодорхой хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгодог байсныг тус тус олгохгүй болсноор тэдний нийгмийн хамгааллын баталгаа буурсан байна.

Мөн гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар тогтоодог болсноор салбар хариуцсан Засгийн газрын гишүүн журмыг тогтоох боломжгүй болсон зэрэг алба хаагчдын эрх зүйн баталгааг дордуулсан нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага урган гарсан.

Иймд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүчингүй болгосон зарим болон өөрчлөлт оруулсан зохицуулалтуудыг эгүүлэн тусгах байдлаар хуулийн төслийг боловсруулах нь

зүйтэй гэж үзсэн.

Цэргийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хязгаарлагдмал байдагтай холбогдуулан цэргийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан зарим зохицуулалтуудыг хуульд дахин тусгах шаардлага тулгамдаж байна.

Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мөнгөн урамшуулал олгох, цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол цэргийн цолын цалинг олгох, цэргийн алба хаагчид ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглох, дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, цэргийн алба хаагчдын нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцох, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги, тэдгээртэй адил нөхцөлд байрлаж, үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сар алба хааснаар тооцох зэрэг цэргийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангасан зохицуулалтуудыг тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульчлах нь зүйтэй юм.

Мөн Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.6 дахь хэсэгт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”, мөн 6.4 дэх хэсэгт “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно” гэж тус тус заасантай нийцүүлэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн хэрэгцээ, шаардлага тодорхойлогдож байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтуудыг хуульд тусгаснаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа сайжирч, цэргийн албандаа итгэх итгэл, алслагдсан цэргийн анги, салбарт үүрэг гүйцэтгэх хүсэл зориг, эрмэлзэл нэмэгдэх, хөдөө орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагч нарын ажиллах сонирхлыг дээшлэх, Зэвсэгт хүчин үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, боломж улам нэмэгдэх болно.

1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд:

Дээрх зохицуулалтуудыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгахгүй байх нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон салбарын хууль тогтоомжид заасан цэргийн алба хаагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлнө гэж дүгнэж байна.

Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг дараах байдлаар тодорхойлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг		Тэдний эрх, ашиг сонирхолд ямар байдлаар нөлөөлж байгаа байдал
1.	Цэргийн алба хаагч	-“улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;” зохицуулалтыг хүчингүй болгосноор алслагдсанд тооцох анги, салбарт алба хааж байгаа цэргийн алба хаагчдын цалин хөлс буурч, хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдах эрхээ эдлэх нөхцөл дордсон;
2.	Цэргийн бэлтгэл үүрэгтэн	-“цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох” зохицуулалтыг хүчингүй болгосноор бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цалинг харьяалах байгууллагаас олгох боломжгүй болсон;
3.	Цэргийн сургуулийн сонсогч	-“Гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлсийг ... төр хариуцах” гэснийг “сургалтын тэтгэлэг” гэж, “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийг газрын гишүүн батална.” гэснийг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж тус тус өөрчилсөн нь суралцагчийн гадаадын цэргийн сургуульд суралцах хугацаандаа албан тушаалын цалин авч, уг цалинг үндэслэн ажилласан жилийг тасралтгүй тооцох эрх зүйн харилцааг зохицуулалтгүй болгосон.

Энэхүү зохицуулалтууд нь цэргийн алба хаагч, цэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн сургуулийн сонсогч, суралцагчид хамаарах бөгөөд тэдний хууль, журмын дагуу цэргийн алба хаах, нийгмийн баталгаа дээшлэх болон ажиллаж, амьдрах нөхцөлд нөлөөлөх боломжтой болно.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тогтоох:

Цэргийн алба хаагчийн алба хаах нийгмийн баталгааг хангах, дээшлүүлэх, хүний нөөцийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, ажиллаж, амьдрах нөхцөл, боломжийг сайжруулах асуудлыг шийдвэрлэхээс гадна “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд боловсруулахаар тусгагдсан Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулагдаж, УИХ-аар батлуулах зорилт хангагдах юм.

ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний тайлангийн 1-т заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго:

“Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа болон албандаа итгэх итгэл нэмэгдэх, үүрэг гүйцэтгэх нөхцөл дээшлэх, эрх зүйн баталгаатай холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан тогтоох”.

1.Цэргийн алба хаагч улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох тохиолдолд албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох;

2.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батлах;

3.Цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолын цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох;

4.Ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглох;

5.Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд мөнгөн тусламж, урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах;

6.Цэргийн алба хаагчид тус хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцон олгох;

7.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

8.Тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги, тэдгээртэй адил нөхцөлд байрлаж, үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сар алба хааснаар тооцох;”

9.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “удаан жил ажилласны” гэснийг “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж өөрчилж тавьсан зорилгыг хангах нь зүйтэй.

ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1.Цэргийн алба хаагч улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох тохиолдолд албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох;

Эерэг тал	Сөрөг тал
➤ Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд томилогдон ажилласан алба хаагчийн хугацааг үүрэг гүйцэтгэж байгаа хугацаанд тооцно.	Байхгүй

2.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батлах;

Эерэг тал	Сөрөг тал
➤ Цэргийн алба хаагчийн цэргийн албандаа итгэх итгэл нэмэгдэнэ. ➤ Цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилнэ. ➤ Цэргийн алба хаагчийн өрхийн орлого нэмэгдэнэ.	Байхгүй

3.Цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох;

Эерэг тал	Сөрөг тал
➤ Цэргийн бэлтгэл болон чөлөөнд байгаа дээд офицеруудын нийгмийн баталгаа дээшилнэ.	Байхгүй

4.Ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглох;

Эерэг тал	Сөрөг тал
➤ Цэргийн албаны үйл ажиллагааны хууль ёсны байдал сайжирна. ➤ Цэргийн алба хаагчид ажлын байрны бэлгийн дарамт, шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлнэ. ➤ Цэргийн алба хаагчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хамгаалагдана.	Байхгүй

5.Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд мөнгөн тусламж, урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах;

➤ Хуулийн зохицуулалттай нийцнэ.	Байхгүй
----------------------------------	---------

6.Цэргийн алба хаагчид хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцон олгох;

<ul style="list-style-type: none"> ➤ Цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилнэ. ➤ Өрхийн орлого нэмэгдэнэ. 	Байхгүй
---	---------

7.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

Эерэг тал	Сөрөг тал
<ul style="list-style-type: none"> ➤ Төрийн цэргийн байгууллагууд тус бүрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр журмыг батлуулна. ➤ Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл илүү тодорхой болж, суралцсан хугацаа нь ажилласан жилд тооцогдох эрх зүйн боломж нэмэгдэнэ. 	Байхгүй

8.Тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги, тэдгээртэй адил нөхцөлд байрлаж, үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сар алба хааснаар тооцох;

Эерэг тал	Сөрөг тал
<ul style="list-style-type: none"> ➤ Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тогтвор, суурьшилтай алба хаах цэргийн алба хаагчдын хүсэл, сонирхол нэмэгдэнэ. ➤ Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт алба хаасан цэргийн алба хаагчид цэргийн алба хаасан хугацааны тэтгэвэр тогтоолгох нөхцөл сайжирна. 	Байхгүй

9.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “удаан жил ажилласны” гэснийг “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж тус тус өөрчлөх;

Эерэг тал	Сөрөг тал
<ul style="list-style-type: none"> ➤ Гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. ➤ Нэр томьёо хууль тогтоомжид нийцнэ. 	Байхгүй

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

6.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл, эрх зүйн баталгааны талаар эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульд тусгаснаар цэргийн алба хаагчдын

хүний эрхийн талаар суурь ойлголт, хандлага, боловсрол дээшлэхээс гадна нийгмийн баталгаа дээшлэх, сайжрах, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалагдах нөхцөл бүрдэнэ. Мөн танин мэдэхүйн үр нөлөө бий болно.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх.	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх.	Тийм	Хуульд шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчилна.	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх.		Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг нөхцөл байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх.		Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх.	Тийм		Холбогдох зохицуулалтыг хуульд тусгахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх.	Тийм		Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх.	Тийм		Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах боломж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын	Тийм		Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг

	олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх.			бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх.		Үгүй	Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгахгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх.	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх.		Үгүй	Хүний эрхийг хязгаарлах талаар зохицуулалт тусгахгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх.		Үгүй	Хүний эрхийг хязгаарлах талаар зохицуулалт тусгахгүй.
3.Эрх агуулагч.	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх.	Тийм		-Монгол Улсын Засгийн газар -Батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх.		Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх.		Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх. /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4.Үүрэг хүлээгч.	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх.	Тийм		Төр, төрийн байгууллага, цэргийн алба хаагч үүрэг хүлээнэ.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх.	Тийм		Ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан

тухай хуульд нийцүүлсэн эсэх.				гадуурхахыг хориглоно.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх.	Тийм		Хуульд тусгах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийтлэг зарчмын хүрээнд боловсруулагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар.	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх. (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх.		Үгүй	Хамааралгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал.	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх.		Үгүй	Үнийн хөөргөдлийг бий болгохгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх.		Үгүй	Хүндрэл, бэрхшээл бий болохгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх.		Үгүй	Монополийг бий болгохгүй.
3.Аж ахуйн нэгжийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг		Үгүй	Шинээр зардал үүсэхгүй.

үйлдвэрлэлийн болон захиргааны зардал.	хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх.			
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх.		Үгүй	Ямар нэгэн хориг тавихгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал.	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх.		Үгүй	Ямар нэгэн нэмэлт зардал бий болохгүй.
5.Өмчлөх эрх.	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх.		Үгүй	Тийм хязгаарлалт бий болохгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ.	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв.	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Цэргийн алба хаагч, бэлтгэл дээд офицерууд/тэдний гэр бүлийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд.	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх.		Үгүй	Ажлын байрыг шинээр бий болгохгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага.	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Улсын төсвийн нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх.		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт хийх шаардлага тавигдахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх.		Үгүй	Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд.	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

11.Олон улсын харилцаа.	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх.	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.
-------------------------	---	------	--	-----------------------------------

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл.	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх.		Үгүй	Шинээр ажлын байр бий болохгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх.		Үгүй	Ажлын байрны цомхотгол бий болохгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Цэргийн алба хаагчдын алба хаах, ажиллах хүсэл сонирхол нэмэгдэнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх.	Тийм		Цэргийн алба хаагчдын алба хаах, ажиллах хүсэл сонирхол нэмэгдэнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх.	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх.	Тийм		Ажлын байранд тогтвортой ажиллах хүсэл сонирхол нэмэгдэнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Алба хаагчдын эрүүл мэнд хамгаалагдана.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх.	Тийм		Алба хаагчдын үүрэг хариуцлага, цэргийн албанд хандах хандлага, нэмэгдэнэ.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх.		Үгүй	Шинээр ажлын стандарт гаргахгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх.		Үгүй	Өөрчлөлт бий болохгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал.	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх.		Үгүй	Тэгш бус байдал үүсгэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд,		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт.			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн байдлаар нөлөөхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун.	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх.	Тийм		Төрийн цэргийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх.	Тийм		Төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөө үзүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал.	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх.	Тийм		Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн байдал сайжирна.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх.	Тийм		Амьдралын хэв маягт эергээр нөлөөлнө.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд,	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй

боловсролын систем.	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх.	Тийм		Алслагдсанд тооцогдсон анги, байгууллага, салбарт тогтвортой алба хаах сонирхолтой алба хаагчдын тоо нэмэгдэнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олгох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Офицер, ахлагч, цэргийн сургуулийн сонсогч дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцах нөхцөл сайжирна.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал.	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх.	Тийм		Ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглоно.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл.	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар.	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч.	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх.		Үгүй	Түлшний хэрэглээг нэмэгдүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах.	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц.	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх.		Үгүй	Бохирдлыг нэмэгдүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол.	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх.		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн		Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

	хэмжээг нэмэгдүүлэх эсэх.			
6.Газрын ашиглалт.	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх.		Үгүй	Ашиглагдаагүй байсан газрын ашиглахгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх.		Үгүй	Газрын зориулалтыг өөрчлөхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх.		Үгүй	Зориулалтыг өөрчлөхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг.	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх.		Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх

гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Асуудлын мөн чанар, цар хүрээ болон цэргийн алба хаагчийн алба хаах нөхцөл, эрх зүйн баталгаатай холбогдох зохицуулалтын хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хуультай уялдсан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

Дэвшүүлсэн ерөнхий зорилгодоо хүрэхийн тулд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох замаар тулгамдсан асуудлыг шийдэх нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Тус хуульд дараах асуудлыг тусган зохицуулах шаардлагатай:

1.Цэргийн алба хаагч улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох тохиолдолд албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох;

2.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батлах;

3. Цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолын цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох;

4.Ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхахыг хориглох;

5.Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд мөнгөн тусламж, урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах;

6.Цэргийн алба хаагчид тус хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцон олгох;

7.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах;

8.Тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги, тэдгээртэй адил нөхцөлд байрлаж, үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сар алба хааснаар тооцох;

9. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “удаан жил ажилласны” гэснийг “төрийн тусгай алба хаасан хугацааны” гэж тус тус өөрчлөх зэрэг болно.

---oOo---

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2022 он
ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь 2016 онд батлагдаж, 2017, 2021 онд өөрчлөлт орсон. Энэ хуулиар цэргийн алба хаагчийн эрх зүйн

байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалттай холбогдох харилцааг зохицуулж байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь 2017 онд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулснаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг дордуулж, албандаа итгэх итгэл, алба хаах хүсэл зориг, эрмэлзлийг бууруулж, эрх ашгийг нь зөрчсөн, зэвсэгт хүчний алслагдсан болон хөдөө орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагч нар цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад ажиллах сонирхлыг бий болгож, ингэснээр цэргийн алба хаагч нарын алба хаах хүсэл сонирхол илт буурч, жилээс жилд ажлаас чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд томилогдох зэрэг сөрөг үр дагаврууд сүүлийн 5 жилийн хугацаанд гарч, хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мөнгөн урамшуулал олгох, цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол цэргийн цолны цалинг олгох, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа алба хаагчийн ажил, албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох, ажлын байрны бэлгийн дарамт, шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах, цэргийн алба хаагчид нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн болон цэргийн цолны цалингийн нийлбэрээс тооцох, алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сар алба хааснаар тооцох зэрэг үзүүлэлтүүдийг нэмэлт, өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдээр сонгож буй бөгөөд эдгээр эрх зүйн нэмэлт, өөрчлөлтүүдийг хуульд тусгаснаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын баталгааг өмнө нь хүчин төгөлдөр үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтын хэмжээнд хүргэх, алба хаагчдын эрх ашиг хамгаалагдах, нийгмийн баталгаа нь дээшлэх, цэргийн алба хаагчийн эрх зүйн хязгаарлалтад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэн холбогдох зохицуулалт орсноор эмэгтэй алба хаагч нарын хуульд заасан эрх ашиг хангагдана.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт, өөрчлөлтүүдийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулснаар алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал сайжирч, 6 сар алба хаасан хугацааг 8 сард тооцож, ажлын байрны бэлгийн дарамт, шахалт, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлж, дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж буй цэргийн алба хаагчдын нийгмийн баталгаа дээшилнэ.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд 2017 онд оруулсан өөрчлөлт нь цэргийн алба хаагчийн албандаа хандах хандлага, итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, улмаар алслагдсан цэргийн анги, салбарт алба хаах хүсэл эрмэлзэл буурч, хүний нөөцийн хомсдолд орж, бусад төрийн цэргийн байгууллагад шилжин алба хаах цэргийн алба хаагчдын тоо өсөхөд нөлөөлж байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь практик үйл ажиллагаанд бодитоор хэрэгжиж, үр дүн хэдий сайтай байгаа боловч Зэвсэгт хүчний алслагдсан болон хөдөө орон нутагт алба хааж байгаа цэргийн алба хаагч нар бусад нэр бүхий байгууллагад ажиллах сонирхол бий болж, ингэснээр цэргийн алба хаагч нарын алба хаах хүсэл сонирхол илт буурч, жилээс жилд ажлаас чөлөөлөгдөх, өөр ажил, албан тушаалд томилогдох зэрэг сөрөг үр дагаврууд сүүлийн 5 жилийн хугацаанд гарч байгаа нь хуулиар онцгойлон заасан эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны

зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг алдагдах, хүний нөөцийн хомсдол үүсэх шалтгааныг бий болгож байгаа нь мөн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болж байгаа болно.

Иймд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүд оруулснаар илүү оновчтой, хүртээмжтэй болон үйл ажиллагаа илүү эрчимжиж, хэрэгжилт сайжирна.

Нэг.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох үе шат

1.1.Зорилгод хүрэх байдал

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтуудыг тусгасан байна. Зохицуулалтуудыг нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт, өөрчлөлтүүдийг тухайн хуульд тусгах шаардлагатай байна.

Хуулийн төслийг түүний үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгааг өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтын төвшинд хүргэх зорилго тавьсан байна.

1.2.Ойлгомжтой байдал

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан нь ойлгомжтой байна.

Хоёр.Тухайн төслийн аль хэсгийн үр нөлөөг үнэлэхээ тогтоох үе шат

Хууль тогтоомжийн төслийн бүх зүйл, заалтын үр нөлөөг үнэлэх нь их хугацаа, зардал, хүн хүч шаардсан ажил байдаг бөгөөд бүхэлд нь үнэлэх боломжгүй учраас тодорхой зүйл, заалтыг сонгон авч үр нөлөөг үнэлэх нь зүйтэй гэж үзсэн.

Иймээс хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо тухайн төслийн хамгийн гол чухал, тавьсан зорилготой холбоотой, агуулгын хувьд хамгийн ач холбогдолтой, анхаарах шаардлагатай гэсэн заалтыг олж тогтоох замаар дараах стандарт шалгууруудын хүрээнд дор дурдсан зохицуулалтуудыг сонгон авсан болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан зохицуулалтуудаас сонгон авлаа.

Хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгааг өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтын төвшинд хүргэх зорилго тавьсан байна.

1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан хуулийн 7 дугаар зүйлд нэмсэн заалт:

“7.1.22.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба

хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална;

7.1.23.цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.”

УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.6-д заасан “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 6.4-т “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.” гэж заасантай нийцэж, цэргийн алба хаагчийн эрх зүйн болон нийгмийн баталгаа өмнө зохицуулагдаж байсан түвшинд хүрэх, илүү дээрдэх гэж үнэлж байна.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалтаас сонгон авлаа.

Хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэхэд цэргийн алба хаагчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг дээшлүүлэх, ажил, албан үүргийн баталгааг хангах, бусад хууль тогтоомжийн зохицуулалтуудтай нийцүүлэх, өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтын төвшинд хүргэх зорилго тавьсан байна.

1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан хуулийн 4 дүгээр зүйлд нэмсэн заалт:

“4.3.11.улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох;”

Энэхүү зохицуулалтыг сонгон авснаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан цэргийн алба хаагчийн эрх зүйн баталгаа дээшилж, алба хаагчийн албандаа хандах хандлага, итгэх итгэл нэмэгдэх юм.

Гурав.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг тооцох хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	“7.1.22.Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална; 7.1.23.цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.”	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Ойлгомжтой байдлыг судлах.	“4.3.11.улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох;”	Ойлгомжтой

			байдлыг судлах
--	--	--	----------------

3.1.Зорилгод дүн шинжилгээ хийх.

Хуулийн төслөөс сонгосон дээрх зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан байна. Энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалд, түүний агуулгатай үр нөлөөг үнэлж байгаа зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийснээр тодорхойлогдож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Батлан хамгаалах талаар Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.3-т “цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох”, 15 дугаар зүйлийн 15.3.4-т “батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, цэргийн алба хаагч, түүний гэр бүл, бэлтгэл чөлөөнд байгаа офицер, ахлагчийн нийгмийн хамгаалал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 5.6-д “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, мөн баримт бичгийн 6.4-т “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Энэхүү эрх зүйн үндэслэлийн хүрээнд өмнө хүчингүй болгосон “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох” гэсэн зохицуулалтыг “Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөн найруулж, “цэргийн дээд офицерын цолтой цэргийн алба хаагч тэтгэвэр тогтоолгосон бол түүнд урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.” гэсэн зохицуулалтуудын агуулгыг хэвээр хадгалан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн найруулж, хуулийн төсөлд нэмэлтээр тусгах нь зүйтэй гэж үзсэн.

Ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага хангагдаж, үзэл баримтлалд тавьсан алба хаагчийн эрх зүйн байдлыг хуучин мөрдөж байсан зохицуулалтаас дордуулалгүй, өмнө байсан төвшинд нь хүргэх, алба хаагчдын эрх зүйн болон нийгмийн баталгааг дээшлүүлэх, цэргийн алба албандаа итгэх итгэл, алба хаах, ажиллаж амьдрах хүсэл зориг, эрмэлзлийг нэмэгдүүлэх зорилгодоо хүрнэ.

3.2.Ойлгомжтой байдлын судлах.

Хуулийн төслөөс сонгосон “улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох” нь гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүд нь тодорхой

бөгөөд хэрэгжүүлэх этгээдүүдэд Засгийн газар, төрийн байгууллага, Батлан хамгаалах яам, ЗХЖШ, түүний харьяа Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар, цэргийн алба хаагчид болон бусад ажилтан, алба хаагч, хэрэглэх этгээдэд Монгол улсын иргэд, аж ахуйн нэгж байгууллага болно.

Бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа цэргийн алба хаагчийн ажил, албан үүрэг нь Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.11-д зааснаар “бүтээн байгуулалтын ажилд оролцох” гэсэн Зэвсэгт хүчний тайван цагт хүлээх үүрэгт хамаардаг, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 208 дугаар зарлигаар батлагдсан “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ын 3.6-д “Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний тухай хууль болон энэхүү журамд зааснаас бусад ажилд оролцуулахгүй байх зарчмыг баримтална.”, 5.1-д “Монгол Улсын Засгийн газар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бүтээн байгуулалтад оролцуулах хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид гаргаж, түүний зөвшөөрлийг үндэслэн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах шийдвэр гаргана.”, 5.5-д “Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрөл, Засгийн газрын шийдвэр, Батлан хамгаалахын сайдын тушаалыг үндэслэн ЗХЖШ-ын даргын тушаалаар бүтээн байгуулалтын болон аж ахуйн ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг томилон ажиллуулна.” гэсэн зохицуулалтуудаар хангагдаж байх тул цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох бүрэн үндэслэлтэй байна.

Тухайлбал, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн ангиуд Дорноговь аймгийн Алтанширээ сум дахь “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын авто зам болон болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын дээд, доод бүтцийн бүтээн байгуулалтын ажил, Дорнод аймгийн Халх гол суманд “Шинэ сум” төслийн бүтээн байгуулалтын ажил зэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд бусад салбарыг тэргүүлэн, голлох үүрэгтэй оролцсоныг төр, иргэд, олон нийт мэднэ.

Дээрх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахдаа тухайн зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа ЗХЖШ, түүний харьяа Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар, цэргийн алба хаагчид болон бусад ажилтан, алба хаагчдаас санал авсан.

Санал авахдаа хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хавсарган хүргүүлсэн болно.

Хуулийн төсөлд тусгагдсан “улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох” гэсэн зохицуулалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой, тодорхой байдлаар тусгагдсан.

Үүнийг шалгах хэрэгслийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад дурдсан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага:

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	Уг шаардлагыг хангасан.
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

Дөрөв.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх үе шат

Тус үр нөлөөг тооцох үнэлгээг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийв.

Энэхүү үнэлгээний ажлын хүрээнд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн асуудлаар салбарын хүрээн дэх байгууллагуудын хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичгээр санал авах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэсэн болно.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү үр нөлөөний судалгаа дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх нь оновчтой байна.

---oOo---